



“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД



ДАРХАН-УУЛ АЙМАГ
2019.04.26

- Дархан-уул аймгийг эко хүнсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аж үйлдвэрлэл, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүс нутаг болгон хөгжүүлэх. Үүний дотор Хонгор сумыг газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр, Орхон сумыг газар тариалан, туслах аж ахуйн чиглэлээр, Шарын гол сумыг уул уурхай, уламжлалт мал аж ахуйн чиглэлээр, Дархан хотыг аж үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр хөгжүүлэх
- “Дархан үйлдвэр технологийн парк”-ийн үйл ажиллагааг Монгол Улсын засгийн газраас тусгайлан бодлогоор дэмжиж эрчимжүүлэх Арьс шир, ноос, ноолуур зэрэг боловсруулах үйлдвэрүүдийг Дарханд шилжүүлэн байршуулах
- МУИС, ХААИС, ШУТИС гэх мэт их, дээд сургуулиудын бүрэлдэхүүн, салбар сургуулиудыг шилжүүлэн төвлөрүүлэх. Мөн үүнтэй уялдуулан Эрдэм шинжилгээний зарим байгууллагуудыг дарханд шилжүүлэн төвлөрүүлэх
- Үндэсний Олон нийтийн радио, телевизээр “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг өдөр тутам суртчилан иргэдийн саналыг авах
- Улаанбаатараас Дарханы чиглэлийн 4 урсгалтай шинэ зам тавихтай зэрэгцүүлээд зам дагуух суурьшлын бүсийн асуудлыг замын төлөвлөлтөд тусгах
- Хөгжлийн эх үүсвэр нь дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэж үзэн Уулын Баяжуулах Эрдэнэт үйлдвэр шиг экспортын зориулалттай 2-3 том үйлдвэр барих
- Эрдэнэтийн гүүрнээс тосгон хүртэл Хараа голыг иж бүлэн ойжуулах санал иргэний төлөөллөөс гаргасан.